

**ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН  
ЯАМНЫ ДЭРГЭДЭХ САЛБАР ЗӨВЛӨЛ**

**1 дүгээр хуралдаанаар хэлэлцсэн асуудлын тойм №1  
2017.02.06**

№	Хэлэлцсэн асуудал	Гарсан шийдвэр
1	Яамны хэлтсийн дарга нарын сонгон шалгаруулалт явуулсан дүн, тухайн ажлын байрны албан тушаалд дүгнэлт гаргуулах, нэр дэвшүүлэх тухай танилцуулах	<p>1.Цэрэндоржийн Уранчимэгийг Цэвэр технологи, хөрөнгө оруулалт, үйлдвэрлэлийн хэлтсийн даргын, Чадраабалын Раднаабазарыг Хуулийн хэлтсийн даргын, Пэрэнлэйлхагвын Бүнчинжавыг Байгаль орчны үнэлгээ, аудитын хэлтсийн даргын, Ногоягийн Батзаяаг Ой, ус, тусгай хамгаалалттай газрын кадастрын хэлтсийн даргын, Шарын Мягмарыг Усны нөөцийн хэлтсийн даргын, Намжилмаагийн Баттулгыг Сав газрын удирдлагын хэлтсийн даргын албан тушаалд тус тус томилуулахаар нэр дэвшүүлж Төрийн нарийн бичгийн дарга Ц.Цэнгэлд санал болгож, тогтоол гаргахаар тогтов.</p> <p>2.Хуулийн хэлтсийн даргын ажлын байр /албан тушаал/-ын тодорхойлолтын ерөнхий шаардлагыг шинэчлэн боловсруулж батлуулахыг Ч.Раднаабазарт зөвлөв. Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2016-08-16-ны өдрийн Б-13 дугаар тушаалаар Төрийн албаны тухай хуулийн 24.1.3/өөрийн санаачилгаар төрийн албанаас чөлөөлөгдөх хүсэлт гаргасан/-аар чөлөөлөгдсөн нь уг хуулийн 17.7-д заасны /төрийн жинхэнэ албанд эргэж ороход энэ зүйлд заасан журмын дагуу мэргэшлийн шалгалт өгнө/ дагуу дүгнэлт гаргаж нэр дэвшүүлэх нь энэхүү шалгаруулалтаар мэргэшлийн шалгалт өгсөнд тооцно гэж гишүүд үзэв.</p> <p>3.Авлигатай тэмцэх газарт хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянуулахыг Цэвэр технологи, хөрөнгө оруулалт, үйлдвэрлэлийн хэлтсийн даргын албан тушаалд нэр дэвшигч Ц.Уранчимэг, Хуулийн хэлтсийн даргын албан тушаалд нэр дэвшигч Ч.Раднаабазар, Байгаль орчны үнэлгээ, аудитын хэлтсийн даргын албан тушаалд нэр дэвшигч П.Бүнчинжав, Ой, ус, тусгай хамгаалалттай газрын кадастрын хэлтсийн даргын албан тушаалд нэр дэвшигч Н.Батзаяа, Усны нөөцийн хэлтсийн даргын албан тушаалд Ш.Мягмар, Сав газрын удирдлагын хэлтсийн даргын албан тушаалд Н.Баттулга нарт тус тус даалгав.</p>
2	Салбар зөвлөлд хандаж гаргасан албан тушаал буурсан тухай Д.Туяа, ажлаас чөлөөлөгдсөн О.Гантулга нарын өргөдлийн тухай	1.Тарвагатай нурууны байгалийн цогцолборт газрын Хамгаалалтын захиргааны газрын даргаар ажиллаж байсан Д.Туяагаас ирүүлсэн албан тушаал буурсан тухай асуудал үндэслэлтэй болох, Захиргааны хэргийн шүүхийн анхан шатны шүүхийн 2016-12-08-ны

		<p>өдрийн 1020 дугаар шийвэрээр өмнө эрхэлж байсан Санхүүгийн хэлтсийн даргын албан тушаалд О.Гантулгыг эгүүлэн тогтоохыг эс зөвшөөрч 2017-01-09-ний өдөр давж заалдан 2017-02-02-ны өдөр "Магадлал" гарч гомдлыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгосон тухай тус яамны итгэмжлэгдсэн төлөөлөгч О.Батсайханы болон хуулийн хэлтсийн дарга Ч.Раднаабазар нарын тайлбарын дагуу өргөдлийн хариуг хүргүүлэхийг Төрийн захиргааны удирдлагын газрын дарга Х.Батжаргалд даалгав.</p>
3	<p>ЦУОШГ-ын төрийн үйлчилгээний албан тушаалын ангиллаас төрийн захиргааны албан тушаалд жинхлэх тухай, Төрийн албаны тэргүүний ажилтан цол тэмдгээр шагнуулах тухай</p>	<p>1. Цаг уур, орчны шинжилгээний газрын төрийн үйлчилгээний албан тушаалын ангиллаас төрийн захиргааны албан тушаалд жинхлэх, албан тушаал дэвшин ажиллах дүгнэлт гаргах, нэр дэвшүүлэх сонгон шалгаруулалт явуулах ажлын хэсэг байгуулахыг Төрийн захиргааны удирдлагын газрын дарга Х.Батжаргал, Цаг уур, орчны шинжилгээний газрын дарга С.Энхтүвшин нарт даалгав.</p> <p>2. "Төрийн албаны тэргүүний ажилтан" цол тэмдгээр Цаг уур, орчны шинжилгээний газрын мэргэжилтэн Д.Сүхбаатарыг шагнуулахаар Төрийн албаны зөвлөлд хүргүүлэхээр тогтов.</p>

Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн 1 дүгээр хуралдаан 2017 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн 13 цаг 55 минутаас Хаан танхимд болно.